



НИЙТИЙН АЛБАНД НИЙТИЙН БОЛОН ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫГ ЗОХИЦУУЛАХ, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР
2012 он

ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

- ▶ “Монгол Улс конвенцийг хэрэгжүүлэх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх,
- ▶ авлигаас урьдчилан сэргийлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгож, хийдлийг арилгах,
- ▶ төрийн албыг нийтийн алба болгон зохион байгуулах, түүний ил тод, хариуцлагатай, шударга үйл ажиллагааг бэхжүүлэх шаардлага

НҮБ-ын Авилгалын эсрэг конвенци:
Оролцогч бүр дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн ил тод байдлыг дэмжих бөгөөд сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх, бэхжүүлэх, төрийн албан тушаалтан нь төрийн албан тушаалтны хувьд гүйцэтгэх чиг үүрэгтэй нь холбогдуулан сонирхлын зөрчил үүсгэж болох албан үүргээс гадуурх үйл ажиллагаа, ажил хөрөнгө оруулалт, хөрөнгө, том хэмжээний бэлэг буюу ашиг орлогын талаар эрх бүхий холбогдох байгууллагад мэдүүлж байх арга хэмжээ, тогтолцоог зохих тохиолдолд дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн тогтоохыг оролцогч улс бүр чармайна” гэж заасан байна.

АСЗ-ИЙГ ТОДОРХОЙЛОХ ҮНДСЭН ОЙЛГОЛТУУД

- ❑ **Зөрчил** – Хүн хувь хүнийхээ хувьд хувийн ашиг сонирхолтой байдаг. Харин албаны болон хувийн ашиг сонирхол нь зөрчилдөхөд сөрөг үр дагавар гардаг.
- ❑ **Албан үүрэг** – Хүлээсэн үүргийнхээ дагуу ёс зүйтэй гүйцэтгэх ёстой ажил алба.
- ❑ **Хувийн сонирхол:**
 - Мөнгөн буюу эдийн ашиг сонирхол /өмч, эрх шилжүүлэх, тусгай зөвшөөрөл эзэмших, хөнгөлөлттэй зээл, бэлэг сэлт авах, дайлуулах г.м/
 - Мөнгөн бус буюу эдийн бус ашиг сонирхол /реклам, зар сурталчилгаа, урлаг соёлын арга хэмжээнд оролцох, ах дүү, хамаатан садан, найз нөхдийнхөө талд шийдвэр гаргах, ямар нэг зүйл дээр давуу тал олгох, таагүй зүйлээс зайлсхийх боломж олж авах г.м/

АСЗ-ИЙН ТӨРЛҮҮД

1. Бодит
2. Ойлгогдохуйц
3. Болзошгүй

БОДИТ АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ:

- ✖ Энэ нь албан тушаалтан албан үүргээ хэрэгжүүлэхэд хувийн ашиг сонирхол нь хангалттай хэмжээнд зүй бусаар нөлөөлж буй нөхцөл байдал.

Жишээ нь: Нийтийн албан тушаалтан өөрийн дүүгийн компанийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулж гэрээ байгуулах.

ОЙЛГОГДОХУЙЦ АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ:

- Энэ нь мэдээлэлтэй иргэд ашиг сонирхлын зөрчил үүссэн байна гэж үнэмшихүйц нөхцөл байдал бий болсныг ойлгоно.
- *Жишээ нь: Нийтийн албан тушаалтан дээрх жишээтэй адил найзынхаа компанийг гүйцэтгэгчээр сонгож гэрээ байгуулжээ. Тухайн тохиолдолд найзынхаа компанийг сонгох нь нийтийн албанд ашигтай байж болно. Мөн нийтийн албан тушаалтан энэ тохиолдолд хувийн ашиг сонирхолд авталгүй шийдвэр гаргасан гэж өөрөө итгэж үнэмшсэн байж болно. Гэвч энэ тохиолдолд нийтийн албанд ашигтай учраас уу, эсвэл хувийн сонирхлын үүднээс тухайн шийдвэрт хүрсэн үү гэдгийг ялгах боломжгүй.*

БОЛЗОШГҮЙ АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ:

- Энэ нь одоогоор ашиг сонирхлын зөрчилтэй нөхцөл байдал үүсээгүй ч ирээдүйд бодит зөрчилд хүргэж болзошгүй нөхцөл байдлыг ойлгоно.
- *Жишээ нь: Нийтийн албан тушаалтан Б ажил үүргийнхээ дагуу А компанитай холбогдох шийдвэр гаргах болсон ба тухайн албан тушаалтны гэр бүлийн хүн уг компанийн захирлаар 7 хоногийн дараа томилогдох нь тодорхой болсон. Энэ тохиолдолд ашиг сонирхлын зөрчил үүсээгүй боловч уг нөхцөл байдлаас ирээдүйд ашиг сонирхлын зөрчил бий болох нь гарцаагүй байна.*

ХУУЛИЙН ЗОРИЛТ

- ✖ урьдчилан сэргийлэх
- ✖ зохицуулах
- ✖ хянах

нийтийн албаны үйл ажиллагааг нийтийн ашиг сонирхолд нийцүүлэх нөхцөлийг баталгаажуулж, төрийн албаны ил тод, итгэл даах байдлыг хангах

Хуулийн бүтэц

5 бүлэг, 30 зүйлтэй.

- 1. Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл**
- 2. Хоёрдугаар бүлэг. Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх**
- 3. Гуравдугаар бүлэг. Албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалт**
- 4. Дөрөвдүгээр бүлэг. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг**
- 5. Тавдугаар бүлэг. Хуулийн хэрэгжилтийг хянах**

Нэр томъёоны тайлбар

“Нийтийн ашиг сонирхол”

*гэж нийтийн албан
тушаалтан Монгол Улсын
Үндсэн хууль, бусад хуулиар
олгогдсон бүрэн эрхээ
хувийн ашиг сонирхлоосоо
ангид тэгш, шударгаар
хэрэгжүүлнэ гэх олон
нийтийн итгэлийг хэлнэ.*



Нэр томъёоны тайлбар

“Хувийн ашиг сонирхол” гэж нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд **өөрөө** болон **түүнтэй хамаарал бүхий этгээдийн** зүгээс нөлөөлж болохуйц эдийн болон эдийн бус ашиг сонирхлыг хэлнэ.

Хамаарал бүхий этгээд:

нийтийн албан тушаалтны

- ❖ гэр бүлийн гишүүн,
- ❖ хамтран амьдрагч,
- ❖ эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү,
- ❖ эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү,
- ❖ бусад **нэгдмэл сонирхолтой этгээд**

Нэр томъёоны тайлбар

Нэгдмэл сонирхолтой
этгээд гэж нийтийн албан
тушаалтантай ашгийн
төлөө үйл ажиллагаагаар
холбоотой хувь хүн,
хуулийн этгээдийг хэлнэ.

Ашгийн төлөө үйл
ажиллагаа гэж компани,
нөхөрлөл, хувиараа
эрхлэх аж ахуй зэрэг аж
ахуй, худалдаа, зээл,
санхүүгийн бүх төрлийн
байгууллагын үйл
ажиллагааг хэлнэ.

Нэр томъёоны тайлбар

“Ашиг сонирхлын зөрчил” гэж нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэх үед түүний хувийн ашиг сонирхол нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөх болон албан үүргээ тэгш, шударгаар хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж болохуйц нөхцөл байдлыг хэлнэ.

Нэр томъёоны тайлбар

Хандив:

Нийтийн албан тушаалтанд тодорхой зориулалтаар, үнэ төлбөргүй, эсхүл нийтэд санал болгож байгаа хөнгөлөлтөөс илүү хөнгөлөлттэй үнээр санхүүгийн эх үүсвэр, эд хөрөнгө шилжүүлэх болон үйлчилгээ үзүүлэхийг хэлнэ.

Бэлэг:

Нийтийн албан тушаалтанд үнэ төлбөргүй эд хөрөнгө өгөх, үйлчилгээ үзүүлэх болон эрх шилжүүлэх, үүргээс чөлөөлөх, нийтийн албан тушаалтантай хамаарал бүхий этгээдийн тусын тулд эрхээс татгалзах зэрэг бусад хэлбэрийн санхүүгийн үр ашгийг хэлнэ.

Хуулийн үйлчлэлд хамаарах этгээд

- төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан;
- төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан;
- төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан;
- хууль тогтоомжийн дагуу, эсхүл улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг түр буюу байнга гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан;
- энэ хуулийн 23.1-д заасан хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах албан тушаалын жагсаалтад орсон албан тушаалтан.

Бусад төрийн албан хаагч?

Хуулийн хэрэгжилтийг хянах

- ✖ Хууль нь бүх нийтээр заавал дагаж мөрдөх дээд хүчин чадалтай хэм хэмжээ тогтоосон акт юм. Тиймээс хуулийн хэрэгжилтийг хянах механизмтай байх нь нэг талаас Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2-т заасан хууль дээдлэх зарчмыг мөрдүүлэхэд, нөгөө талаас хууль тогтоомжийн үр нөлөөг сайжруулахад чухал ач холбогдолтой байдаг.
- ✖ Түүнчлэн албан тушаалтан өөрийн үйл ажиллагааны шударга, төвийг сахисан байдалдаа ёс зүйн шалтгаанаар эргэлзээ төрвөл албан үүргээ гүйцэтгэхээс, эсхүл давхар ажил, албан тушаал эрхлэхээс татгалзах үүрэгтэй. Энэ нь хууль тогтоомжийг сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлж буй хэрэг юм.

Хуулийн хэрэгжилтийг хянах

*Нийтийн албанд
нийтийн болон
хувийн ашиг
зохицуулах, ашиг
сонирхлын зөрчлөөс
урьдчилан сэргийлэх
тухай хуулийн 28
дугаар зүйл.*

- ✗ УИХ-ын Хууль зүйн байнгын хороо – Авлигатай тэмцэх газар, Шүүхийн ерөнхий зөвлөл
- ✗ Авлигатай тэмцэх газар - бусад бүх этгээд

1. УИХ-ын Хууль зүйн байнгын хороо
2. Авлигатай тэмцэх газар
3. Шүүхийн ерөнхий зөвлөл

Хариуцлага

Захиргааны хариуцлага

Шүүгч

- Мөнгөн торгууль ногдуулах
- Албан тушаалаас чөлөөлөх
- Хууль бус шийдвэрийг хүчингүй болгох

Сахилгын шийтгэл

Эрх бүхий албан
тушаалтан

- Сануулах
- Цалинг хуульд заасан тодорхой хувь хэмжээгээр бууруулах
- Албан тушаал бууруулах
- Нийтийн албанаас халах

29.3. Шүүгчээс захиргааны хариуцлага хүлээлгэсэн нь тухайн албан тушаалтанд сахилгын шийтгэл хүлээлгэхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

Эрх зүйн бусад зохицуулалт

- ✖ Албан тушаалтан дипломат журмаар бэлэг авах, тайлагнах, зарцуулах журам */16.3/*
- ✖ Албан тушаалтны төрийн өмчлөлд шилжүүлсэн бэлэг, үйлчилгээний үнэ, хөлсийг үнэлэх, хадгалах, зарцуулах журам */16.10/*
- ✖ Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийн маягт, түүнийг бүртгэх, хянан шалгах, хадгалах журам */23.8/*
- ✖ Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам */29.5 /*

БУСАД ...

**Албан тушаалтан өөрт ногдуулсан
сахилгын шийтгэлийг холбогдох
этгээд болон нийтэд өөрийн зардлаар
хүргэнэ.**

**Энэ журмыг Авлигатай
тэмцэх газар батална.**

Үндэслэлгүйгээр хөрөнгөжих

- ✖ Албан тушаалтан 6 сарын албан тушаалын цалин орлогоос илүү хөрөнгө, орлогыг хууль ёсны дагуу олсон болохыгоо үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй тохиолдолд үндэслэлгүйгээр баяжсан гэж үзнэ.
/ Авлигын эсрэг хуулийн 7.1.8 /
- ✖ Нийтийн албан тушаалтан хууль ёсны орлогоос гадна их хэмжээгээр эд хөрөнгө, орлого олсон нь тогтоогдсон бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг 3-аас дээш 5 жил хүртэл хугацаагаар хасч, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 251-ээс 500 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 3 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэнэ.
/Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 170.1 /

**Анхаарал хандуулсанд
баярлалаа!**

www.iaac.mn

Утас: 7011-2465